

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Хэрлэнбаян-Улаан тосгоны Захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ХЭА-2026/019/НА-СТА-ТТЗ**

Чингис хот 2026 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар Утас: 70562112 Цахим хаяг: khentii@audit.gov.mn  Аудитын менежер: Д.Оюунтуяа Утас: 99775390 Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn  Аудитор: Н.Хэрлэнбаяр Утас: 89051308 Цахим хаяг: kherlenbayarn@audit.gov.mn  Цахим хаяг: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a>
-----------------------	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН  
ГАЗАР**

АЗДТГ-ын 3 дугаар давхарт, Сариг баг, Хэрлэн сум,  
Хэнтий аймаг, 23119, Утас/Факс: (976) 70562112,  
Цахим шуудан: khentii@audit.gov.mn

2026.03.25 № 518

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хэнтий аймгийн Хэрлэнбаян-Улаан тосгоны Захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн нэгтгэсэн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Хэрлэнбаян-Улаан тосгоны төвлөрүүлэн захирагч нь 2025 онд орон нутгийн төсөвт 135,320.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 157,963.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 22,643.5 мянган төгрөгөөр буюу 16.7 хувиар давуулан биелүүлсэн байна.

**Аудитын гол асуудал**

Хэрлэнбаян-Улаан тосгоны Захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 66,698.0 мянган төгрөгийн 2 алдаа, зөрчил илэрч 34,698.0 мянган төгрөгийн 1 алдааг аудитын явцад санхүүгийн тайланд залруулж, Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй 32,000.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлсэн.

### **Бусад асуудлын хэсэг**

Тосгоны иргэдийн нийтийн хурлын 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн Долоодугаар хуралдаанаар Захирагчийн үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2025 оны төлөвлөгөөний биелэлтийг 85.2 хувийн гүйцэтгэлтэй үнэлсэн байна.

Орон нутгийн хөгжлийн сангаас 183,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 10 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 107,000.0 мянган төгрөгийн 4 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. Эрүүл мэндийн төвийн гүний худаг гаргах ажлын төсөвт өртөг хүрэлцээгүйн улмаас 2026 онд хэрэгжүүлэхээр хойшлогдож, 46,000.0 мянган төгрөгийн 5 төсөл, арга хэмжээ ОНХС-ийн санхүүжилт жилийн эцэст оройтож орж ирснээс шалтгаалан хийгдээгүй байна. Иймд ОНХС-аар хийгдэх төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг хангаж ажиллах шаардлагатай.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ж.ГАНБААТАР

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ****2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан**

/мянган төгрөг/

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>391,083.31</b>	<b>249,441.86</b>
2	1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	340,589.79	196,449.39
3	1.1.3 АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	1,001.22	240
4	1.1.4 УРЬДЧИЛГАА	7а, 7б	2,900	2,900
5	1.1.5 БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	46,592.3	49,852.48
<b>6</b>	<b>1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>236,143.06</b>	<b>337,650.35</b>
7	1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	236,143.06	337,650.35
8	1.2.2.02 Биет хөрөнгө		232,543.06	334,150.35
9	1.2.2.03 Биет бус хөрөнгө	13	3,600	3,500
<b>10</b>	<b>1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2</b>		<b>627,226.37</b>	<b>587,092.22</b>
<b>11</b>	<b>2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>		<b>167.23</b>	<b>20</b>
12	2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		167.23	20
13	2.1.1.03 Өглөг		167.23	20
<b>14</b>	<b>2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>		<b>627,059.14</b>	<b>587,072.22</b>
15	2.2.1 Засгийн газрын хувь оролцоо		627,059.14	587,072.22
16	2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал		74,265.46	74,265.46
17	2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн		470,842.65	430,855.72
18	2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		81,951.04	81,951.04
<b>19</b>	<b>2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5</b>		<b>627,226.37</b>	<b>587,092.22</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөг/

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	<b>1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>		<b>896,732.16</b>	<b>583,363.94</b>
2	<b>1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО</b>		<b>128,629.94</b>	<b>156,612.53</b>
3	1.1.1.03.1 Орлогын албан татвар		113,001.86	139,067.49
4	1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар		113,001.86	139,067.49
5	1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар		11,918.24	14,673.34
6	1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж		3,709.84	2,871.7
7	<b>1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1а, 1б</b>	<b>145,851.55</b>	<b>426,751.41</b>
8	1.1.1.04.3 Тусламжийн орлого		0.0	329,693.01
9	<b>1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>		<b>622,250.68</b>	<b>0.0</b>
10	<b>1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2а, 2б</b>	<b>580,547.45</b>	<b>599,705.91</b>
11	<b>1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>580,547.45</b>	<b>599,705.91</b>
12	<b>1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		<b>567,069.75</b>	<b>598,992.91</b>
13	1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		287,882.33	351,901.74
14	1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		35,023.29	39,573.85
15	1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		91,039.54	106,584.76
16	1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал		22,834.91	21,321.89
17	1.1.2.01.1.05 Нормативт зардал		1,486.2	0.0
18	1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал		51,254.83	25,638.2
19	1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал		8,262.5	6,666.6
20	1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		1,422.93	14,315.17
21	1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал		67,863.23	32,990.69
22	<b>1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>		<b>13,477.7</b>	<b>713</b>
23	<b>1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>		<b>316,184.71</b>	<b>-16,341.97</b>
24	<b>1.2.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>		<b>27,000</b>	<b>0</b>
25	<b>1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)</b>		<b>-27,000</b>	<b>0</b>
26	<b>1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)</b>		<b>289,184.71</b>	<b>-16,341.97</b>

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөг/

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	337,874.43		337,874.43
2	1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	337,874.43		337,874.43
3	1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн	289,184.71		289,184.71
4	1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	627,059.14		627,059.14
5	1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	627,059.14		627,059.14
6	1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-23,644.96		-23,644.96
<b>7</b>	<b>1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>603,414.19</b>		<b>603,414.19</b>
<b>8</b>	<b>1.7 Тайлант үеийн үр дүн</b>	<b>-16,341.97</b>		<b>-16,341.97</b>
<b>9</b>	<b>1 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл</b>	<b>587,072.22</b>		<b>587,072.22</b>

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөг/

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	<b>1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>752,550.62</b>	<b>558,728.94</b>
2	<b>1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>128,629.94</b>	<b>156,612.53</b>
3	1.1.1.1.03.1 Орлогын албан татвар	113,001.86	139,067.49
4	1.1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	11,918.24	14,673.34
5	1.1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	3,709.84	2,871.7
6	1.1.1.1.03.8.01 Бусад нийтлэг төлбөр, хураамж	3,709.84	2,871.7
7	<b>1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,670</b>	<b>402,116.41</b>
8	1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	1,670	2,650
9	1.1.1.1.04.3 Тусламжийн орлого	0.0	329,693.01
10	1.1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.0	69,773.4
11	<b>1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>622,250.68</b>	<b>0.0</b>
12	<b>1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>528,426.05</b>	<b>579,846.4</b>
13	<b>1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>528,426.05</b>	<b>579,846.4</b>
14	<b>1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>514,948.36</b>	<b>578,758.4</b>
15	1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	287,715.11	352,046.51
16	1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35,024.51	39,575.09
17	1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	91,039.54	106,449.76
18	1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	23,969.84	19,507.47
19	1.1.1.2.01.1.05 Нормативт зардал	1,486.2	1,389.1
20	1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	54,027.73	29,482.7
21	1.1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал	8,262.5	6,666.6
22	1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,422.93	11,641.17
23	1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	12,000	12,000
24	<b>1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>13,477.7</b>	<b>1,088</b>
25	<b>1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>224,124.56</b>	<b>-21,117.46</b>
26	<b>1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>40,989.9</b>	<b>123,022.94</b>
27	<b>1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>40,989.9</b>	<b>123,022.94</b>
28	1.1.2.2.01.1 Дотоод эх үүсвэрээр	40,989.9	123,022.94
29	<b>1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-40,989.9</b>	<b>-123,022.94</b>
30	<b>1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>183,134.66</b>	<b>-144,140.4</b>
31	1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	157,455.13	340,589.79
32	1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	340,589.79	196,449.39

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөг/

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Төлөвлөгөө	2. Гүйцэтгэл
<b>1</b>	<b>3.1.01.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>1,003,272.20</b>	<b>924,240.01</b>
<b>11</b>	<b>3.1.01.1.1 Татварын орлого</b>	<b>133,820.00</b>	<b>156,612.53</b>
110	3.1.01.1.1.1 Орлогын албан татвар	122,400.00	139,067.49
1100	3.1.01.1.1.1.1 Хувь хүний орлогын албан татвар	122,400.00	139,067.49
110001	3.1.01.1.1.1.1.01 Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	120,250.00	137,249.83
110002	3.1.01.1.1.1.1.02 Үйл ажиллагааны орлого	2,150.00	1,807.66
110004	3.1.01.1.1.1.1.04 Хөрөнгө борлуулсны орлого	-	10.00
113	3.1.01.1.1.3 Хөрөнгийн албан татвар	10,620.00	14,673.34
113001	3.1.01.1.1.3.1 Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	500.00	1,083.69
113002	3.1.01.1.1.3.2 Бууны албан татвар	120.00	150.00
113004	3.1.01.1.1.3.4 Малд ногдуулах албан татвар	10,000.00	13,439.65
118	3.1.01.1.1.8 Бусад татвар, төлбөр, хураамж	800.00	2,871.70
1180	3.1.01.1.1.8.1 Бусад нийтлэг төлбөр, хураамж	800.00	2,871.70
118001	3.1.01.1.1.8.1.01 Улсын тэмдэгтийн хураамж	-	700.00
118009	3.1.01.1.1.8.1.08 Хог хаягдлын үйлчилгээний хураамж	800.00	2,171.70
<b>12</b>	<b>3.1.01.1.2 Татварын бус орлого</b>	<b>869,452.20</b>	<b>767,627.48</b>
120	3.1.01.1.2.1 Нийтлэг татварын бус орлого	11,362.00	2,650.00
120003	3.1.01.1.2.1.3 Торгуулийн орлого	1,500.00	1,650.00
120004	3.1.01.1.2.1.4 Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	9,862.00	1,000.00
122	3.1.01.1.2.3 Тусламжийн орлого	788,316.80	695,204.08
122003	3.1.01.1.2.3.3 Аймаг нийслэлээс авсан татаас	326,498.40	326,498.40
122005	3.1.01.1.2.3.5 Төсвөөс санхүүжих	461,818.40	368,705.68
123	3.1.01.1.2.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	69,773.40	69,773.40
123002	3.1.01.1.2.4.2 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	69,773.40	69,773.40
<b>II</b>	<b>3.1.01.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>873,180.40</b>	<b>1,312,210.31</b>
<b>21</b>	<b>3.1.01.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>695,648.30</b>	<b>1,211,631.51</b>
<b>210</b>	<b>3.1.01.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>694,065.30</b>	<b>598,247.93</b>
2101	3.1.01.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	396,334.40	351,875.01
210101	3.1.01.2.1.1.1.01 Үндсэн цалин	194,641.20	174,287.59
210102	3.1.01.2.1.1.1.02 Нэмэгдэл	171,430.80	152,208.62
210103	3.1.01.2.1.1.1.03 Унаа хоолны хөнгөлөлт	3,432.00	2,706.00
210104	3.1.01.2.1.1.1.04 Урамшуулал	26,830.40	22,672.79
2102	3.1.01.2.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	49,541.80	39,553.65
210201	3.1.01.2.1.1.2.01 Тэтгэврийн даатгал	33,688.40	30,235.43

210202	3.1.01.2.1.1.2.02	Тэтгэмжийн даатгал	3,963.30	2,578.10
210203	3.1.01.2.1.1.2.03	ҮОМШӨ-ний даатгал	1,981.70	1,289.05
210204	3.1.01.2.1.1.2.04	Ажилгүйдлийн даатгал	1,981.70	1,089.72
210205	3.1.01.2.1.1.2.05	Эрүүл мэндийн даатгал	7,926.70	4,361.35
2103	3.1.01.2.1.1.3	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	130,271.70	106,449.76
210301	3.1.01.2.1.1.3.01	Гэрэл, цахилгаан	59,853.60	39,556.56
210302	3.1.01.2.1.1.3.02	Түлш, халаалт	69,398.40	66,273.50
210303	3.1.01.2.1.1.3.03	Цэвэр, бохир ус	1,019.70	619.70
2104	3.1.01.2.1.1.4	Хангамж, бараа материалын зардал	21,580.00	18,777.80
210401	3.1.01.2.1.1.4.01	Бичиг хэрэг	2,500.00	1,984.90
210402	3.1.01.2.1.1.4.02	Тээвэр, шатахуун	12,000.00	11,000.00
210403	3.1.01.2.1.1.4.03	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,000.00	4,298.00
210405	3.1.01.2.1.1.4.05	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,130.00	702.90
210406	3.1.01.2.1.1.4.06	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	950.00	792.00
2105	3.1.01.2.1.1.5	Нормативт зардал	1,850.00	589.10
210503	3.1.01.2.1.1.5.03	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,850.00	589.10
2106	3.1.01.2.1.1.6	Эд хогшил, урсгал засварын зардал	59,626.20	50,694.84
210601	3.1.01.2.1.1.6.01	Багаж, техник, хэрэгсэл	21,986.20	21,916.14
210602	3.1.01.2.1.1.6.02	Тавилга	600.00	-
210603	3.1.01.2.1.1.6.03	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	540.00	325.00
210604	3.1.01.2.1.1.6.04	Урсгал засвар	36,500.00	28,453.70
2107	3.1.01.2.1.1.7	Томилолт, зочны зардал	8,000.00	6,666.60
210702	3.1.01.2.1.1.7.02	Дотоод албан томилолт	8,000.00	6,666.60
2108	3.1.01.2.1.1.8	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,861.20	11,641.17
210801	3.1.01.2.1.1.8.01	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,932.00	10,932.00
210802	3.1.01.2.1.1.8.02	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324.20	-
210803	3.1.01.2.1.1.8.03	Даатгалын үйлчилгээ	540.00	241.11
210804	3.1.01.2.1.1.8.04	Тээврийн хэрэгслийн татвар	250.00	248.67
210805	3.1.01.2.1.1.8.05	Тээврийн хэрэгслийн оношлогоо	145.00	-
210806	3.1.01.2.1.1.8.06	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	450.00	-
210807	3.1.01.2.1.1.8.07	Газрын төлбөр	220.00	219.39
2109	3.1.01.2.1.1.9	Бараа үйлчилгээний бусад зардал	14,000.00	12,000.00
210901	3.1.01.2.1.1.9.01	Бараа үйлчилгээний бусад зардал	14,000.00	12,000.00
<b>213</b>	<b>3.1.01.2.1.4</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,583.00</b>	<b>613,383.58</b>
2131	3.1.01.2.1.4.1	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	612,535.58
213103	3.1.01.2.1.4.1.03	Төсвийн санхүүжилт	-	612,535.58
2132	3.1.01.2.1.4.2	Бусад урсгал шилжүүлэг	1,583.00	848.00
213209	3.1.01.2.1.4.2.08	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,583.00	848.00

<b>22</b>	<b>3.1.01.2.2</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>167,670.10</b>	<b>100,578.80</b>
223001	3.1.01.2.2.4	Бусад хөрөнгө	167,670.10	100,578.80
<b>23</b>	<b>3.1.01.2.3</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>9,862.00</b>	<b>-</b>
230001	3.1.01.2.3.1	Эргэж төлөгдөх зээл	9,862.00	-
<b>8</b>	<b>3.1.01</b>	<b>ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ</b>	<b>130,091.80</b>	<b>(387,970.30)</b>
<b>9</b>	<b>3.1</b>	<b>АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>(130,091.80)</b>	<b>387,970.30</b>
<b>7</b>	<b>3</b>	<b>Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт</b>	<b>(130,091.80)</b>	<b>387,970.30</b>
<b>4</b>	<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>340,589.79</b>
<b>5</b>	<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>196,449.39</b>

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/мянган төгрөг/

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Тайлант он
1	1.1.1.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	3,194.61
12	1.1.1.1.1 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,194.61
122	1.1.1.1.1.1 Тусламжийн орлого	3,194.61
1221	1.1.1.1.1.1.1 Хандив тусламж /дотоод/	3,194.61
12213	1.1.1.1.1.1.1.1 Нэмэлт санхүүжилтийн орлого	3,194.61
350014	1.1.1.1.1.1.1.1.4 Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	547.61
350015	1.1.1.1.1.1.1.1.5 Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,647.00
II	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,954.61
21	1.1.1.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	2,954.61
210	1.1.1.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,954.61
2101	1.1.1.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	171.50
210104	1.1.1.2.1.1.1.4 Урамшуулал	171.50
2102	1.1.1.2.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21.44
210201	1.1.1.2.1.1.2.1 Тэтгэврийн даатгал	21.44
2104	1.1.1.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	729.67
210401	1.1.1.2.1.1.4.1 Бичиг хэрэг	75.00
210402	1.1.1.2.1.1.4.2 Тээвэр, шатахуун	324.67
210403	1.1.1.2.1.1.4.3 Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	30.00
210406	1.1.1.2.1.1.4.6 Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	300.00
2105	1.1.1.2.1.1.5 Нормативт зардал	800.00
210503	1.1.1.2.1.1.5.3 Нормын хувцас, зөөлөн эдлэл	800.00
2106	1.1.1.2.1.1.6 Эд хогшил, урсгал засварын зардал	1,232.00
210602	1.1.1.2.1.1.6.2 Тавилга	528.00
210604	1.1.1.2.1.1.6.4 Урсгал засвар	704.00
4	1.1.1 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	240.00
5	1.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(240.00)
6	1 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(240.00)

### **3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Хэрлэнбаян-Улаан тосгоны Захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд тосгоны орон нутгийн төсвийн 5 байгууллага, 1 төрийн сан , 2 тусгай сан нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 4 байгууллагад дүгнэлт гаргаж, 3 байгууллагын санхүүгийн тайлан аудитын түүвэрт хамрагдсан байна.

Аймаг дахь Төрийн аудитын газар Захирагчийн ажлын алба, Ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэгийн санхүүгийн тайланд, “Ари фaйнэнс аудит” ХХК Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайланд тус тус аудит хийж “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт өгсөн.

#### **3.1 Тус тосгоны харьяа орон нутгийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн талаар:**

Орон нутгийн төсвийн байгууллагуудын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 66,698.0 мянган төгрөгийн 2 алдаа, зөрчил илрүүлснээс 34,698.0 мянган төгрөгийн 1 алдааг санхүүгийн тайланд залруулж, 32,000.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлсэн. Үүнд:

##### **Захирагчийн ажлын алба**

1. Санхүүгийн тайланд тайлант оны элэгдлийн зардлыг 34,698.0 мянган төгрөгөөр дутуу тусгасныг нөхөн тооцож нэмэгдүүлж залруулав.

##### **Орон нутгийн хөгжлийн сан**

1. Шилэн дансны цахим хуудсанд ОНХС-ийн төлөвлөгөөг хурлаар батлагдсан төсөл, арга хэмжээ бүрээр мэдээлээгүй байна .

*Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.*

#### **3.2 Тус тосгоны харьяа улсын төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн талаар:**

Улсын төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 1,949,790.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 187,324.1 мянган төгрөгийн 12 алдааг аудитын явцад залруулж, 1,066.2 мянган төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоож, 1,761,399.7 мянган төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өгсөн байна. Үүнд:

##### **Соёлын төв**

1. Санхүүгийн тайлан дахь Аж ахуйн материал дансны эхний үлдэгдэл 5,000.0 мянган төгрөгөөр, Бусад хангамжийн материал дансны эхний үлдэгдэл 180.0 мянган төгрөгөөр дэлгэрэнгүй тайлангаас зөрүүтэй илэрхийлэгдснийг дэлгэрэнгүй тайлангийн үлдэгдлээр санхүүгийн тайланд нэмэгдүүлж залруулав.
2. Санхүүгийн тайлан дахь Машин тоног төхөөрөмж /компьютер/ дансны хуримтлагдсан элэгдлийн эхний үлдэгдэл 1,142.1 мянган төгрөгөөр, Тавилга, аж ахуйн эд хогшил дансны хуримтлагдсан элэгдлийн эхний үлдэгдэл 654.3 мянган төгрөгөөр дэлгэрэнгүй тайлангаас зөрүүтэй илэрхийлэгдсэн, тухайн дансдын тайлант хугацааны элэгдлийн зардлыг 15,361.8 мянган төгрөгөөр дутуу тайлагнасныг элэгдлийн зардлыг нөхөн тооцож нэмэгдүүлж залруулав.
3. Санхүүгийн тайланд тусгаагдах НДШ-ийн өглөгийн эцсийн үлдэгдэл 158.6 мянган төгрөгийг өглөгөөр тусгаагүй байсныг нийгмийн даатгалын тайлан, цалингийн тооцооллыг тулган нэмэгдүүлж залруулав.
4. Төсвийн гүйцэтгэлийн тайланд төлөвлөгөөг 9,646.3 мянган төгрөгөөр, зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 3,249.9 мянган төгрөгөөр зөрүүтэй тусгасан,

төвлөрүүлэх шилжүүлгийн тохиргоо бичилт хийгээгүй, Мөнгөн гүйлгээний тайлангийн хөрөнгө оруулалтын мөнгөн зарлагын дүнг 2,000.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасныг батлагдсан төсвийн хуваарь, гүйцэтгэлтэй тулган залруулав.

5. Худалдан авсан 3,000.0 төгрөгийн үнэ бүхий нам даралтын зуухыг үндсэн шууд зардалд бүртгэснийг үндсэн хөрөнгөнд орлогод авч залруулав.
6. Нийгмийн даатгалын газраас тогтоосон торгуулийг цалингийн зардлаас шилжүүлэн барагдуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

7. Шилэн дансны цахим сайтад худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг оруулаагүй, төсвийн гүйцэтгэлийн мэдээг тогтмол хугацаа хоцроон оруулах, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалт, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгнөөс дээш үнийн дүн бүхий гүйлгээний мэдээллийг оруулаагүй, 5 сая төгрөгнөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээний мэдээллийг дутуу мэдээллэх зэргээр хуулийн хэрэгжилтийг хангалтгүй хэрэгжүүлж байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.

8. Үлдэх өртөггүй 13,040.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө санхүүгийн тайланд бүртгэлтэй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгсөн.

### **Ерөнхий боловсролын сургууль**

1. Санхүүгийн тайлан дахь Аж ахуйн материал дансны эхний үлдэгдэл 19,1 мянган төгрөгөөр, Бусад хангамжийн материал дансны эхний үлдэгдэл 300.0 мянган төгрөгөөр дэлгэрэнгүй тайлангаас зөрүүтэй илэрхийлэгдснийг нэмэгдүүлж залруулав.
2. Санхүүгийн тайлан дахь Машин тоног төхөөрөмж /компьютер/ дансны эхний үлдэгдэл 7,143.8 мянган төгрөгөөр,Тавилга эд хогшил дансны эхний үлдэгдэл 5,200.0 мянган төгрөгөөр дэлгэрэнгүй тайлангаас зөрүүтэй илэрхийлэгдснийг нэмэгдүүлж залруулав.
3. Санхүүгийн тайлан дахь Барилга, байгууламж, орон сууц дансны хуримтлагдсан элэгдлийн эхний үлдэгдэл 12,920.8 мянган төгрөгөөр, Машин тоног төхөөрөмж /компьютер/ дансны хуримтлагдсан элэгдлийн эхний үлдэгдэл 2,370.1 мянган төгрөгөөр, Тавилга, аж ахуйн эд хогшил дансны хуримтлагдсан элэгдлийн эхний үлдэгдэл 2,568.2 мянган төгрөгөөр дэлгэрэнгүй тайлангаас дутуу илэрхийлэгдсэн, тухайн дансдын тайлант хугацааны элэгдлийн зардлыг 10,256.6 мянган төгрөгөөр дутуу тайлагнасныг тайлант хугацааны элэгдлийн зардлыг нөхөн тооцоолж нэмэгдүүлж залруулав.
4. Төсвийн гүйцэтгэлийн тайланд төлөвлөгөөг 444.7 мянган төгрөгөөр, зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 33,046.1 мянган төгрөгөөр зөрүүтэй тусгасан, төвлөрүүлэх шилжүүлгийн тохиргоо бичилт хийгээгүй, Санхүүгийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан орлогыг 415.0 мянган төгрөгөөр дутуу илэрхийлснийг батлагдсан төсвийн хуваарь, гүйцэтгэлтэй тулган залруулав.
5. Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг тухайн сарын тооцоолсон цалингийн зардлаас зөрүүтэй тайлагнаж байна. /ажилчдын төлсөн НДШ-ийг огт

тайлагнахгүй байх, тооцоолсон цалингаас илүү, дутуу тайлагнах, ажлаас чөлөөлөгдсөн хүн дээр НДШ тооцож тайлагнах гэх мэт/.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.

6. Шилэн дансны цахим сайтад худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг оруулаагүй, төсвийн гүйцэтгэлийн мэдээг тогтмол хугацаа хоцроон оруулах, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын дүн оруулаагүй, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгнөөс дээш үнийн дүн бүхий гүйлгээний мэдээлэл, 5 сая төгрөгнөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээний мэдээллийг дутуу мэдээллэх зэргээр хуулийн хэрэгжилтийг хангалтгүй хэрэгжүүлж байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.

### **Хүүхдийн цэцэрлэг**

1. Санхүүгийн тайлан дахь Машин тоног төхөөрөмж /компьютер/ дансны хуримтлагдсан элэгдлийн эхний үлдэгдэл 144.7 мянган төгрөгөөр, Бусад үндсэн хөрөнгө дансны хуримтлагдсан элэгдлийн эхний үлдэгдэл 64.2 мянган төгрөгөөр дэлгэрэнгүй тайлангаас зөрүүтэй илэрхийлэгдсэн, тухайн дансдын тайлант хугацааны элэгдлийн зардлыг 406.6 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан алдааг нөхөн тооцоолж нэмэгдүүлж залруулав.
2. Санхүүгийн тайланг зөрүүтэй илэрхийлсэн алдааг батлагдсан төсвийн хуваарь, гүйцэтгэлтэй тулган залруулав.
3. Нийгмийн даатгалын газраас тогтоосон торгуулийг цалингийн зардлаас шилжүүлэн барагдуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

4. Ээлжийн амралттай ажилтнад 566.2 мянган төгрөгийн цалин илүү тооцон олгосон байна..

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох.

5. Шилэн дансны цахим системд шаардлагатай мэдээллийг тогтмол хугацаа хоцроон оруулах, огт оруулахгүй байх, үнийн дүнг зөрүүтэй оруулах зэргээр хуулийн хэрэгжилтийг хангалтгүй хэрэгжүүлж байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.

### **Эрүүл мэндийн төв**

1. Байгууллагын эзэмшилд буй газрыг гэрчилгээн дэх тоо хэмжээнээс 1010 м.кв-аар дутуу бүртгэснийг нэмэгдүүлж залруулав.
2. Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээн дээрхи Засгийн газрын өмчийн дүн санхүүгийн тайланд зөрүүтэй тусгагдсан байна..

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.

### **3.3 Тосгоны Захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн талаар:**

Хэрлэнбаян-Улаан тосгоны Захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар 300.0 мянган төгрөгийн 1 алдаа илэрснийг аудитын явцад санхүүгийн нэгтгэсэн тайланд залрууллаа. Үүнд:

1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайланд замд яваа мөнгө 300.0 мянган төгрөгийг тусгаагүй байна.

#### **3.3.1 Төлбөрийн акт**

*Байхгүй.*

#### **3.3.2 Албан шаардлага**

*Байхгүй.*

#### **3.3.3 Зөвлөмж**

*Байхгүй.*

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		НББ-ийн бодлогыг буруу хэрэгжүүлсэнтэй холбоотой		Буруу тусган илэрхийлсэн		Мэдээллийг тусгажүй оржигдуулсантай холбоотой		Үүнээс				Зөвлөмж	
									Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЗАА	1.0	34,698.0			1.0	34,698.0			1.0	34,698.0				
ОНХС	-	-					-	-						
ХХС	-	-												
БХС	-	-												
ОНӨААТҮГ	-	-												
<b>ОНБ-ын дүн</b>	<b>1.0</b>	<b>34,698.0</b>	-	-	<b>1.0</b>	<b>34,698.0</b>	-	-	<b>1.0</b>	<b>34,698.0</b>	-	-	-	-
ЕБС	4.0	74,684.5			4.0	74,684.5			4.0	74,684.5				
Цэцэрлэг	2.0	70,226.7			2.0	70,226.7			2.0	70,226.7				
Соёлын төв	5.0	40,393.0			5.0	40,393.0			5.0	40,393.0				
ЭМТ	1.0	2,020.0			1.0	2,020.0			1.0	2,020.0				
<b>УТБ-ын дүн</b>	<b>12.0</b>	<b>187,324.1</b>	-	-	<b>12.0</b>	<b>187,324.1</b>	-	-	<b>12.0</b>	<b>187,324.1</b>	-	-	-	-
Хэрлэнбаян-Улаан Захирагч	1.0	300.0					1.0	300.0	1.0	300.0				
<b>ТТЗ-ын дүн</b>	<b>1.0</b>	<b>300.0</b>	-	-	-	-	<b>1.0</b>	<b>300.0</b>	<b>1.0</b>	<b>300.0</b>	-	-	-	-
<b>Нийт дүн</b>	<b>14.0</b>	<b>222,322.1</b>	-	-	<b>13.0</b>	<b>222,022.1</b>	<b>1.0</b>	<b>300.0</b>	<b>14.0</b>	<b>222,322.1</b>	-	-	-	-

##### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
ЗАА	-	-											
ИТХ	-	-											
ОНХС	-	-											
ХХС	-	-											
ОНӨААТҮГ	-	-											
<b>ОНБ-ын дүн</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>
ЕБС	1.0	-	-	-	1.0	-							
Цэцэрлэг	2.0	816.2	2.0	816.2									
Соёлын төв	2.0	250.0	1.0	250.0	-	-	1.0	-					
ЭМТ	1.0	-	-	-	1.0	-							
<b>УТБ-ын дүн</b>	<b>6.0</b>	<b>1,066.2</b>	<b>3.0</b>	<b>1,066.2</b>	<b>2.0</b>	<b>-</b>	<b>1.0</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>
Хэрлэнбаян-Улаан Захирагч	-	-	-	-	-	-	-	-					
<b>ТТЗ-ын дүн</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>Нийт дүн</b>	<b>6.0</b>	<b>1,066.2</b>	<b>3.0</b>	<b>1,066.2</b>	<b>2.0</b>	<b>-</b>	<b>1.0</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
ЗАА	-	-											
ОНХС	1.0	32,000.0			1.0	32,000.0							
ХХС	-	-											
<b>ОНБ-ын дүн</b>	<b>1.0</b>	<b>32,000.0</b>	-	-	<b>1.0</b>	<b>32,000.0</b>	-	-	-	-	-	-	-
ЕБС	1.0	1,216,468.2			1.0	1,216,468.2							
Цэцэрлэг	1.0	348,360.2			1.0	348,360.2							
Соёлын төв	1.0	196,571.3			1.0	196,571.3							
ЭМТ	-	-											
<b>УТБ-ын дүн</b>	<b>3.0</b>	<b>1,761,399.8</b>	-	-	<b>3.0</b>	<b>1,761,399.8</b>	-	-	-	-	-	-	-
Хэрлэнбаян-Улаан Захирагч	-	-											
<b>ТТЗ-ын дүн</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>Нийт дүн</b>	<b>4.0</b>	<b>1,793,399.8</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>4.0</b>	<b>1,793,399.8</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

**5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	5	4	1		4			
2	ОНТС	2		2					
3	ТТЗ	1	1			1			
	<b>НИЙТ</b>	<b>8</b>	<b>5</b>	<b>3</b>		<b>5</b>			